

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2011 он)

Зөвлөмж201106/01. Шувууны талаархи зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээг олон улсын иргэний нисэхийн байгууллага ИКАО-гийн бичиг баримт Annex14 Aerodromes Volum1-ийн 9.4; Annex 15 ENR 5.6; Doc 9137; Doc 9332 –д заасан заалтуудтай нийцүүлсэн байх.

Зөвлөмж201106/02. Зөвлөмж 20070607-д заасан Иргэний нисэхийн агаарын хөлгүүд Шувуутай мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх Монгол улсын нисэх буудлууд түүний удирдлагын бүсэд авах арга хэмжээний үндэсний бодлогыг боловсруулж гаргах. *National bird control policy*

Зөвлөмж201106/03. Зөвлөмж 20070608-д заасан Шувуутай мөргөлдөх аюулаас хамгаалах бодлогын хүрээнд үндэсний зөвлөлийг байгуулж түүний үйл ажиллагааг тогтмолжуулах. *National bird strike committee.*

Зөвлөмж201106/04. Шувуутай мөргөлдөх аюулаас хамгаалах нисэх буудлуудын хөтөлбөрийг буудал болгоны онцлогийг тусган загварчилсан байдлаар боловсруулж хэрэгжүүлэх. *Airport bird control programmes..*

Зөвлөмж 201108/05. SAAB-340 маягийн агаарын хөлгөөр нислэгийн үед нисэх баг мөстөлт эхэлснийг буруу тодорхойлж алдаа гаргаж байгаатай холбоогдуулан эрсдлийг багасгах зорилгоор SAAB онгоцны үйлдвэрлэгчээс гаргасан SB-ын (Service Bulletin) дагуу мөстөлт дохиолох систэм (ICE DETECTOR) суурилуулах.

Зөвлөмж 201108/06. АНУ, FAA (Federal Aviation Administration) агентлагаас 2008 онд гаргасан AD 2008-06-11(Airworthiness Directives) нислэгт тэнцэх чадварын удирдамжийн дагуу мөстөлтөөс хамгаалах системийн ашиглалтын журамд болон нислэгийн ашиглалтын хязгаарлалтуудад өөрчлөлт оруулах.

Зөвлөмж 201108/07. SAAB-340 маягийн агаарын хөлгийн Operation Bulletin No. 32, AFM Limitation нислэг ашиглалтын хязгаарлалт, AOM Supplement Operation in cold weather and icing conditions болон бусад холбогдолтой материалуудаас нийт нисэх бүрэлдэхүүнд сургалт хийх, компанийн сургалтын программд оруулж энэ төрлийн сургалтыг тогтмолжуулах.

Зөвлөмж 201108/08. SAAB-340 онгоцны нислэгийн өгөгдөхүүн бичигч /FDR/ системийн олон улсын UTC цаг болон огноог “Maintenance Practices 31-30-05” баримтын дагуу тохируулга хийх.

Зөвлөмж 201108/09. Монгол улсад ашиглагдаж байгаа болон тухай маягийн агаарын хөлөгт ашиглагддаг хөөрч буух зурвас /ХБЗ/-н дээр V1 хурдыг тодорхойлох аргачлал, аюулгүй хөөрөлт үйлдэх программ (Take-off safety training program)–ын дагуу нисэх бүрэлдэхүүнд сургалт хийх.

Зөвлөмж 201108/10. SAAB-340 агаарын хөлгийн хоёр хөдөлгүүрийн хоорондох хөөрөлтийн горимд үүсэж байгаа эргэлтийн момент болон сэнсний эргэлтийн зөрүүнд тохируулга хийж, үйлдвэрлэгчээс заагдсан хэмжээнд байлгах арга хэмжээ авах

Зөвлөмж 201110/11. Арилжааны болон тусгай, онцгой үүргийн нислэг гүйцэтгэх буй агаарын тээврийн компани, операторуудын бүтцэд нислэг үйлдвэрлэлийн нэгж /OPERATION/-ыг бий болгох, нислэг бүрийг эхлэхээс дуусах хүртлэх хугацаанд хянах, зохион байгуулах, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах асуудлыг компанийн үйл ажиллагааны шаардлага болгон тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Зөвлөмж 201110/12. Нислэг үйлдвэрлэлийн нэгж /OPERATION/-ыг туршлага, чадвартай мэргэжлийн боловсон хүчин, удирдлагын бичиг баримтаар хангах арга хэмжээг авах.

Зөвлөмж 201110/13. Олон улсын стандарт шаардлага хангасан сансрын хиймэл дагуулын тусламжтайгаар агаарын хөлгийн нислэгийн чиглэл, өндөр, хурд газарт болон агаар дах байрлалыг нисгэгчийн оролцоогүйгээр тодорхойлж газарт мэдээллийг дамжуулдаг, түүнийг хянан зохицуулдаг тогтолцоог агаарын тээврийн компаниудын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд мөрдүүлж хэрэгжүүлэх.

Зөвлөмж 201110/14. НХҮА-наас нэг ээлжинд ажиллах нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зохицуулах, удирдах, үйл ажиллагаанд оролцож байгаа ажиллагсдын ажлын байр бүр дээр хүн тус бүрийн хийх ёстой ажлыг нэг бүрчлэн тодорхойлсон, бусад ажлын байруудтай харилцан ажиллах журам дэс дараалалыг нарийн тогтоосон ажлын технологи процедур гарган эрсдлийг удирдах систем бүхий бүтэц зохион байгуулалтыг бий болгон мөрдөх.

Зөвлөмж 201110/15. Нислэгийн төлөвлөлт, хөдөлгөөний удирдлагын стрип бэлтгэх, хэвлэх, идэвхижүүлэх, ашиглах үйл ажиллагаа байнгын хяналтанд байх систем тогтоох.

Зөвлөмж 201110/16. Хэнгэрэгтэй ууланд байрлуулсан DVOR/DME, Говь-Алтайд байрлуулсан VOR/ILS/MLS-ийн байрлалыг ICAO-гийн annex 11, doc 9426-гийн 5.2.2-ын “a” заалтад нийцсэн байх арга хэмжээг авах.

Зөвлөмж 201110/17. Агаарын хөлгийн нисэх зөвшөөрлийг дамжин өнгөрөх агаарын зам, өнгөрөлтийн цэг бүрийн нислэгийн хөдөлгөөний урсгал нэтрүүлэх чадвар, зохицуулалт хийх боломжийг тооцон олгодог систем тогтоох.

Зөвлөмж 201110/18. Нислэгийн удирдагч нарын англи хэлний мэдлэгийн түвшинг ANNEX 1-ийн 1.2.9, APPENDIX 1. ATTACHMENT -A-д заасан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА